

# ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГ



## **НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

**2026 он**

## СУДАЛГААНЫ БАГ

АХЛАГЧ: Доктор (Ph.D), профессор Г.Алтанзаяа

Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн хүндэт Ерөнхийлөгч

ГИШҮҮД: Доктор (Ph.D) Ү.Галмандах

Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн Ерөнхийлөгч

Доктор (Ph.D), профессор Ч.Энхбаяр

Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн “Татвар&Бизнес” сэтгүүлийн редакцын зөвлөл, МУИС-ийн профессор

Доктор (Ph.D), профессор Б.Авирмэд

Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн Судалгааны менежментийн хорооны дарга, СЭЗИС-ийн ахлах багш, профессор

Г.Хишигзул

Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн Тамгын газрын дарга

НАРИЙН БИЧИГ: М.Мөнхнаран

Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн нягтлан бодогч

|   |           |
|---|-----------|
| <b>НЭГ. НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОХ, ҮНДЭСЛЭЛ</b> ..... | <b>4</b>  |
| <b>ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ</b> .....  | <b>6</b>  |
| 2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал .....                          | 7         |
| 2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал .....                       | 8         |
| 2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал .....                              | 9         |
| 2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал .....                     | 10        |
| 2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал .....                                | 11        |
| <b>ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ</b> .....                                     | <b>11</b> |
| 3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал .....   | 11        |
| 3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....   | 12        |
| 3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал .....   | 13        |
| 3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....   | 14        |
| 3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....  | 14        |
| <b>ДӨРӨВ. ҮР ДҮНГ ДҮГНЭЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ</b> .....  | <b>14</b> |
| 4.1. ДҮГНЭЛТ.....   | 14        |
| 4.2. ЗӨВЛӨМЖ .....  | 15        |
| <b>АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ</b> .....   | <b>17</b> |

## УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-ын дагуу хийгдсэн энэхүү үнэлгээ нь “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-ийн үзэл баримтлалын бодит хэрэгжилтийн боломж, эдийн засаг, нийгмийн үр нөлөө, хууль зүйн уялдаа болон хэрэгжих чадавхыг судалж, үнэлэхэд зорьсон.

Үнэлгээний ажлын хүрээнд хуулийн төслийн зорилт, үндэслэл, зохицуулалтын хүрээ болон хэрэгжилтийн нөлөөллийн түвшнийг бодлогын нийцэл, хуулийн уялдаа, хэрэгжилтийн боломж, нийгэм эдийн засгийн үр нөлөө, институцийн чадавх, эрсдэлийн удирдлага зэргийг үнэлэх замаар “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д заасан шалгуур үзүүлэлтээр үнэлсэн болно.

Үнэлгээний судалгаанд УИХ-ын төсвийн байнгын хороо, Сангийн яам, Татварын ерөнхий газар, худалдаа аж үйлдвэрийн танхим болон мэргэжлийн байгууллагууд, бизнесийн төлөөллүүдийн өргөн хүрээнд явагдсан хэлэлцүүлгийн санал дүгнэлт, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан”, мөн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааны тайлан”-уудыг ашиглаж, олон улсын байгууллагуудын татварын бодлого, хууль тогтоомжийн үнэлгээний чиг хандлагатай харьцуулан дүн шинжилгээ хийсэн.

Энэхүү ажлын зорилго нь Монгол Улсын Засгийн газрын “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр тавьсан бодлого уг хуулийн төсөлд биеллээ олж хэрэгжих нөхцөл болох, татварын суурь өргөтгөх бодит боломж, татвар төлөгчийн ачааллын тэнцвэр, хэрэгжилтийн эрсдэл, үр нөлөөг тогтоох замаар дүгнэлт, зөвлөмж өгөхөд чиглэсэн болно.

Үнэлгээний үр дүнд НӨАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь татварын ил тод байдлыг нэмэгдүүлэх, суурийг өргөтгөх, буцаан олголт, цахим баримтын даган мөрдөлтийг сайжруулах зэрэг эерэг үр нөлөөтэй гэж дүгнэхийн зэрэгцээ зарим зохицуулалтыг хэрэгжүүлэх, хүлээн зөвшөөрөлтөд нөлөөлөх хяналт, механизмын зохицуулалтын дутагдал, нэр томъёоны болон эрсдэл үүсэх нөхцөл, технологийн шийдэлд анхаарах шаардлагатай гэж үзэв.

Эцэст нь уг хуулийн төсөл нь бодлого болон хэлэлцүүлгийн үр дүнд гарсан практик асуудлуудыг шийдэх боломжтой гэсэн дүгнэлт гарч, сайжруулж анхаарах зөвлөмжүүдийг гаргасан, НӨАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлан мөрдүүлж өнөөгийн асуудлуудаа шийдвэрлэх гэсэн нийгмийн хүлээлт өндөр байгааг хэлэх нь зүйтэй болов уу.

## **НЭГ. НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОХ, ҮНДЭСЛЭЛ**

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан”, мөн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааны тайлан”-ууд болон холбогдох баримт бичгийг судлан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд үр нөлөөний судалгааг гүйцэтгэлээ.

Татварын эрх зүйн зарчим<sup>1</sup>д үндэслэн нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төслийн гол зохицуулалт ба өөрчлөлт нь:

1. Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн босго нэмэгдүүлэх
2. Татвар төлөх хугацааг хойшлуулах

Хууль тогтоомжийн тухай хуулийн 17.1<sup>2</sup>, Монгол Улсын сангийн сайдын 2025 оны есдүгээр сарын 1-ний өдрийн 01/8077 тоот албан бичгийн дагуу хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу гүйцэтгэлээ.

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалын 2.9-д заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
4. Ойлгомжтой байдал
5. Харилцан уялдаа

Тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоо хийгдсэн<sup>3</sup> тул “зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

### **Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:**

#### **1. Зорилгод хүрэх байдал:**

Хуулийн төслийн үнэлгээний үндсэн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу өнөөгийн тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. НӨАТ-ын тухай хууль нь 2015 онд батлагдаж, 2016 оны 1

<sup>1</sup> Г.Алтанзаяа. Татвар, УБ, 2020. Х212

<sup>2</sup> 12.1.3.хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал; (Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт)

<sup>3</sup> Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо

дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дахь жилдээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан”-д уг хуулийн өнөөгийн байдал, олон нийтээс ирсэн олон саналуудын үндсэнд шийдвэрлэж шинэчлэх практик асуудлыг тогтоосон.

Мөн "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.2.1-д "Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх"-ээр заасан хүрээнд бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын суурь тогтолцооны тогтвортой байдлыг хангах, татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулах, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгох, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэргийг зорилт болгосон.

2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал”-д уг хуулийн төслийн зорилго нь “бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, татвар төлөгчдөөс татварын хууль тогтоомжийг сайжруулахтай холбоотойгоор ирүүлсэн нийтлэг саналуудыг тусгахад чиглэнэ”<sup>4</sup> гэжээ.

Иймээс НӨАТ-ын тухай хуулийн төслийн зохицуулалт нь уг хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон практик үндэслэл шаардлагад нийцэж буй эсэх, уг зорилгыг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалт болсон эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

## **2. Практикт хэрэгжих боломж:**

Хуулийн төсөл нь одоо хэрэгжиж байгаа Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг шинэчлэх үзэл баримтлалд туссан зорилгыг хангах үүднээс нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн босгыг нэмэгдүүлэх, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг хойшлуулах зохицуулалтууд хуулийн төсөлд шинээр орсон. Эдгээр зохицуулалт нь практик шаардлагаас үүдэлтэй шинэ зохицуулалтууд тул татварын албаны зүгээс болон татварын эрх зүйн харилцаанд оролцогч хувь болон хуулийн этгээдүүд хэрэгжүүлэх боломжтой, асуудлыг шийдвэрлэх эсэхийг үнэлэх зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

## **3. Ойлгомжтой байдал:**

Хуулийн төсөл нь татвар төлөгч, бизнес эрхлэгч, төрийн байгууллагын хэрэглээнд хэр зэрэг ойлгомжтой, хэрэглэхэд хялбар, маргаан багатай байхаас шалтгаалан амжилттай хэрэгжих эсэх нь шалтгаална.

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал “хууль тогтоомжийн ойлгомжтой байдлыг үнэлэх шалгуур” дараах чиглэлээр тодорхойлогддог. Үүнд:

1. Хэл найруулга, нэр томъёоны нэг мөр байдал
2. Хуулийн төслийн бүтэц, зохион байгуулалт
3. Хуулийн заалтуудын уялдаа холбоо
4. Хууль хэрэгжүүлэгч, дагаж мөрдөгч талуудын ойлгох чадвар
5. Олон улсын жишигтэй нийцэл, эрх зүйн тодорхой байдал

---

<sup>4</sup> Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал. х2

Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх татварын алба болон татварын эрх зүйн харилцаанд оролцогч хувь хүн болон хуулийн этгээдүүдийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлнө. Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

#### **4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал:**

Хуулийн төсөлд туссан зохицуулалтууд нь хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх татварын алба болон татварын эрх зүйн харилцаанд оролцогч хувь хүн болон хуулийн этгээдүүдийн хувьд хүлээн зөвшөөрөгдөх эсэхийг үнэлэх зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно. Хуулийн төсөл нь нийгмийн хэрэгцээ, үзэл баримтлалын дагуу боловсруулагдсан зарим зохицуулалт нь оролцогч талуудын хүлээн зөвшөөрөлтөөс хэрэгжүүлэлтийн үр дүн хамаарна.

#### **5. Харилцан уялдаа:**

Хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх зэргийг тогтоох нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлага хангасан эсэхийг шалгах зорилго тул тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

### **ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ**

Хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төсөлд шинээр нэмж орж буй, голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгож буй заалтын үр нөлөөг үнэлэхэд чиглэсэн болно.

Тохирох шалгах хэрэгсэл нь урьдчилан тогтоосон шалгуур үзүүлэлтээс шалтгаалан харилцан адилгүй байх бөгөөд шалгуур үзүүлэлт тус бүрд нийцсэн дараах шалгах хэрэгсэл байна. Эдгээр шалгах хэрэгсэл нь хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтэд нийцсэн, боломжит арга, хэрэгсэл юм.

| <b>Шалгуур үзүүлэлт</b>    | <b>Тохирох шалгах хэрэгсэл</b>            |
|----------------------------|---|
| Зорилгод хүрэх байдал      | Зорилгод дүн шинжилгээ хийх               |
| Практикт хэрэгжих боломж   | Практикт турших                           |
| Ойлгомжтой байдал          | Ойлгомжтой байдлыг шалгах                 |
| Хүлээн зөвшөөрөгдөх байдал | Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх |
| Харилцан уялдаа            | Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах     |

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар сонгов.

| <b>№</b> | <b>Шалгуур үзүүлэлт</b> | <b>Тохирох шалгах хэрэгсэл</b> |
|----------|-------------------------|--------------------------------|
|----------|-------------------------|--------------------------------|

|    |                            |  |
|----|----------------------------|--|
| 1. | Зорилгод хүрэх байдал      | Зорилгод дүн шинжилгээ хийх  |
| 2. | Практикт хэрэгжих боломж   | Төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судлах   |
| 3. | Ойлгомжтой байдал          | Шалгах хэрэгслийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой томъёологдсон эсэхийг шалгаж тогтооно                               |
| 4. | Хүлээн зөвшөөрөгдөх байдал | Хүлээн зөвшөөрөгдөх байдлыг тодорхой үзүүлэлтийн дагуу үнэлнэ  |
| 5. | Харилцан уялдаа            | Харилцан уялдааг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах, мөн бусад баримт, бичигт дүн шинжилгээ хийх замаар судлах |

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт бүрээр тус бүрд нь авч үзье.

## **2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал**

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийн зохицуулалтыг шалгаж, үр нөлөөг нь үнэлэх бол тухайн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн эсхүл, түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл, заалтуудыг сонгоно. Үүний тулд тухайн хуулийн төслийн үзэл баримтлалтай сайтар танилцаж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг хэрхэн тодорхойлсон, энэхүү үндэслэл, шаардлага нь зорилгыг хэрхэн илэрхийлж байгаа эсэхийг үнэлэв. Энэ хүрээнд дараах асуудлуудыг зорилгодоо нийцсэн эсэхийг авч үзлээ.

1. Хуулийн төслийн зорилго нь "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.2.1-т "Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх"-ээр заасан зорилгод нийцсэн эсэх

2. 2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал”-ын зорилгын дагуу уг хуулийн төсөл нийцсэн эсэх

Иймд хуулийн төслөөс дээрх зүйлсийн дагуу зорилгоо хангах зохицуулалт хийгдсэн эсэхийг “зорилгод хүрэх байдал”-ын үр нөлөөг үнэлэе.

1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн эдийн засгийн бодлогын 3.2.1. "Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл"-ээр дараах зорилт<sup>5</sup> - уудыг хангахаар тодорхойлсон. Үүнд:

- бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах
- татварын суурь тогтолцооны тогтвортой байдлыг хангах
- татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлэх
- цахим татварын тогтолцоог сайжруулах
- бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах
- татварын дэмжлэгүүдийг оновчтой болгох
- хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих

<sup>5</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368388631&showType=1>

2. Дээрх бодлогоо хуулийн төслийн үзэл баримтлал<sup>6</sup> -д дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- 1) Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих
- 2) Татвар төлөгчийн татварын хууль тогтоомжийг сайжруулахтай холбоотойгоор ирүүлсэн нийтлэг саналуудыг тусгахад чиглэнэ гэдгээ үзэл баримтлалдаа тусгасан.

Хуулийн төслийн үзэл баримтлалын зорилго бүрд үр нөлөөг тооцох эсэхээ авч үзье. Үүнд:

1) “Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих” зорилгод хүрэх байдлын үр нөлөөг үнэлэхэд

1. НӨАТ-ын босго, аж ахуйн нэгжид тулгарч буй асуудлыг шийдэх эсэх
2. НӨАТ-ын тайлагнал, татвар төлөх хугацааны зохицуулалтыг авч үзье.

| №  | Зорилгод хүрэх байдал   | Сонгосон зүйл заалт              |
|----|---|----------------------------------|
| 1. | НӨАТ-ын босго, аж ахуйн нэгжид тулгарч буй асуудлыг шийдэх эсэх | НӨАТ суутган төлөгчийн босго     |
| 2  | НӨАТ-ын тайлагналын хугацаа, цахим тайлагналын зохицуулалт      | Татвар төлөх хугацааны хөнгөлөлт |

2) “Татвар төлөгчийн татварын хууль тогтоомжийг сайжруулахтай холбоотойгоор ирүүлсэн нийтлэг саналуудыг тусгах” зорилгод хүрэх байдлын үр нөлөөг үнэлэхдээ:

1. Татвар төлөгчдийн хүлээлт, хуулийн төслийг дэмжиж буй байдал
2. Төсөлд ирүүлсэн саналыг авч үзэж тусгасан эсэхийг авч үзье.

Татвар төлөгч болон мэргэжлийн байгууллагын санал дээр тулгуурлан нэр томъёо, хэрэгжүүлэх процесст мэргэжлийн түвшний оролцогчдын саналыг илүү тодорхой төсөлд тусгасан байдлыг үнэлэхэд

| №  | Зорилгод хүрэх байдал                                | Сонгосон зүйл  |
|----|--|--|
| 1. | Татвар төлөгчдийн хүлээлт, төслийг дэмжиж буй байдал | Эрх зүйн нэгдсэн системд төсөлд санал өгөх системд 6,000 орчим иргэн үзсэнээс 79.2% нь дэмжсэн байна. <a href="https://legalinfo.mn/mn/discussion?id=1">https://legalinfo.mn/mn/discussion?id=1</a>        |
| 2. | Төсөлд ирүүлсэн саналыг авч үзсэн эсэх (%)           | 11,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 176,000 орчим санал хүлээн авсан. <sup>7</sup> 110,000 гаруй иргэн, аж ахуйн нэгжээс, санал <sup>8</sup> ирсэн |

## 2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

<sup>6</sup> Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал. х3

<sup>7</sup> Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал. х3

<sup>8</sup> Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. 2025 он. Х12

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийг энэ хуулийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг дээр харуулснаар сонгон авч үнэлгээ хийхэд зорьсон.

Зорилго: Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн бодит хэрэгжилтийн боломж, эрх зүйн болон институцийн орчны нийцлийг судалж, практикт хэрэгжих магадлал, саад бэрхшээлийг үнэлэхийг зорьсон болно. Хэрэгжүүлэх эрх зүйн нийцэл, байгууллага, хүний нөөц, технологи хангагдсан эсэх, эдийн засгийн болон зан үйлийн хүчин зүйл нь практикт хэрэгжих боломжийг илэрхийлнэ. Үүнд:

### 1. Эрх зүйн нийцлийн түвшин

| Үзүүлэлт                        | Тайлбар  |
|---------------------------------|--|
| Олон улсын стандарттай нийцэл   | ЭЗХАХБ-ын НӨАТ-ын гарын авлага болон Европын холбооны заавар 2006/112/ЕС-ийн бүтэцтэй нийцтэй эсэх |
| Дотоод хууль тогтоомжийн уялдаа | Татварын ерөнхий хууль, Гаалийн тухай хууль, ААНОАТ-ын хяналтын нийцэл уялдаа                      |
| Буцаан олголтын журам           | Иргэн, байгууллагын итгэлцэлд тулгуурлаж буй, урамшууллын системийн үр нөлөө                       |

### 2. Институцийн хэрэгжилтийн чадавх

| Үзүүлэлт                              | Тайлбар   |
|---------------------------------------|---|
| Татварын байгууллагын дижитал чадавх  | Цахим төлбөрийн баримт, цахим нэхэмжлэлийн системийн хамралт худалдаа үйлчилгээний нэгж, ялангуяа орон нутгийн оролцооны зохицуулалт, тодорхой бус байдал |
| Хяналт, өгөгдлийн шинжилгээний чадавх | Өгөгдөлд суурилсан хяналт хязгаарлагдмал байдал, хүний хүчин зүйл давамгайлал, мэдлэгийн дутагдал, ойлголтын ялгаатай байдал                              |

### 3. Эдийн засгийн болон зан үйлийн хүчин зүйл

- Жижиг, дунд бизнесийн татварын чадвар: 2024 оны байдлаар татвар төлөгчөөр бүртгэлтэй нийт 259 мянган хуулийн этгээдийн 54,9% нь НӨАТ суутган төлөгчөөр бүртгэлтэй бөгөөд үүний 15% нь 50 саяас доош орлоготой, 20% нь 50-400 саяын хооронд орлоготой, 65% нь 400 саяас дээш орлоготой байна.
- Иргэдийн баримт авах соёл: 2024 оны байдлаар татварын албанд бүртгэлтэй татвар төлөгчийн тоо 2 сая 505 мянга байна. Үүнээс 345 мянган иргэн бизнес эрхлэгч боловч 8 мянга нь НӨАТ суутган төлөгчөөр бүртгэлтэй байна. Нийт хэвлэсэн и-баримт 1 их наяд 375 тэрбум байгаа бөгөөд үүнээс ердөө 3,7% (51,9 сая)-ыг иргэн хэвлэсэн байна. Цахим төлбөрийн баримт хүлээн авах идэвх, хэрэгжилтийн байдал.
- Эерэг тал нь НӨАТ-ын цахим төлбөрийн баримтыг нийтээр дагах механизм бүрдсэн эсэх.

### 2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлт нь хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томьёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой

байгаа эсэхийг үнэлнэ. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй, товч, тодорхой, ойлгоход хялбар байхыг ойлгоно. Уг хуулийн төсөл нь татвар төлөгч, бизнес эрхлэгч, төрийн байгууллагын хэрэглээнд хэр зэрэг ойлгомжтой, хэрэглэхэд хялбар, маргаан багатай байхаас шалтгаалан амжилттай хэрэгжих эсэх нь шалтгаална.

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал “хууль тогтоомжийн ойлгомжтой байдлыг үнэлэх шалгуур” дараах 5 чиглэлээр тодорхойлдог:

1. Хэл найруулга, нэр томъёоны нэг мөр байдал
2. Хуулийн төслийн бүтэц, зохион байгуулалт
3. Хуулийн заалтуудын уялдаа холбоо
4. Хууль хэрэгжүүлэгч, дагаж мөрдөгч талуудын ойлгох чадвар
5. Олон улсын жишигтэй нийцэл, эрх зүйн тодорхой байдал

1. Хэл найруулга, нэр томъёоны нэг мөр байдалд - Төслийн нэр томъёоны тодорхойлолт, нэр томъёонуудын нэг мөр байдал.

2. Хуулийн төслийн бүтэц, зохион байгуулалт – Бүтэц нь өмнөх хуулийн найруулгаас шинэ зүйл заалтууд нэмэгдсэн байна. Татвар төлөгч, татвар ногдуулах, хасалт хийх, буцаан олгох, тайлагнал гэсэн логик гинжээр холбогдсон байдал.

3. Хуулийн заалтуудын уялдаа холбоо - НӨАТ-ын суурь ухагдахуун (борлуулалт, импорт, татвар ногдуулах, хасалт, татвар төлөх, буцаан олгох) нэг мөр байдал хоорондын уялдаатай байдал.

4. Хууль хэрэгжүүлэгч, дагаж мөрдөгч талуудын ойлголт, мэдлэгийн чадамж

5. Олон улсын жишигтэй нийцэл, эрх зүйн тодорхой байдал - ЭЗХАХБ, ОУВС, ЕХ-ийн НӨАТ-ын үндсэн зарчмуудтай нийцэж байгаа эсэх, үндсэн ойлголтууд агуулгын зөрчилгүй эсэх

#### **2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал**

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” гэсэн шалгуур үзүүлэлт нь тухайн төслөөр шинээр бий болгож буй зохицуулалтыг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх эсэхийг үнэлэх учраас олон нийтийн оролцоо, хүлээн зөвшөөрөлтийг шаардах зохицуулалтад анхаарлаа.

ЭЗХАХБ-аас Олон нийтийг татан оролцуулах загвараар хэрхэн хүлээн зөвшөөрөх вэ<sup>9</sup> гэдэгт олон нийтийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын шинэ хэмжүүрүүдийн талаар ЭЗХАХБ-ын шинжээчдээс удирдамж гарчээ. НӨАТ-ын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нийгэм, олон нийтийн хүлээн зөвшөөрөх байдалд НӨАТ-ын зохицуулалтын эрх зүйн болон хэрэгжүүлэгч байгууллагын хүчин чадалд итгэх хандлагаас ихээхэн хамааралтай.

<sup>9</sup> Getting the Public on Side. How to Make Reforms Acceptable by Design.  
[https://www.oecd.org/content/dam/oecd/en/publications/reports/2025/03/getting-the-public-on-side\\_3a30e3c5/262255fd-en.pdf](https://www.oecd.org/content/dam/oecd/en/publications/reports/2025/03/getting-the-public-on-side_3a30e3c5/262255fd-en.pdf)  
(тэгш бус байдлыг бууруулах зорилготой бодлогын эрэлт хэрэгцээ, олон нийтийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг бүрдүүлэхэд ойлголт, хандлага)

Хүлээн зөвшөөрөгдөх байдалд авч үзэх үнэлгээний үзүүлэлтүүдэд дараахыг хэрэглэдэг байна.

| № | Үзүүлэлт   | Тайлбар   | (%) |
|---|--|---|-----|
| 1 | Ил тод байдал ба нээлттэй байдал                     | Хуулийн төсөл боловсруулахад оролцогч талуудын оролцоо, санал тусгах механизм                             | 20  |
| 2 | Шударга, тэгш байдлын хүлээлт                        | НӨАТ-ын шинэчилсэн тогтолцоо татвар төлөгчдийн хооронд шударга хандлагатай гэж хүлээн зөвшөөрөгдөх түвшин | 20  |
| 3 | Татвар төлөгчдийн итгэлцэл                           | Татварын орлого зөв, үр ашигтай зарцуулагдаж байна гэж үзэх хувь  | 15  |
| 4 | Хэрэгжилтийн хялбар байдал (compliance cost)         | ААН, иргэдийн хувьд тайлагнал, бүртгэл, хяналт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй эсэх                              | 15  |
| 5 | Бизнесийн өрсөлдөх чадварт үзүүлэх нөлөөний ойлголт  | Хуулийн төсөл бизнесийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ гэсэн хүлээлт                                       | 10  |
| 6 | Нийгмийн шударга байдлын ойлголт (equity perception) | Хуулийн хөнгөлөлт, чөлөөлөлт шударга хуваарилагдаж байна гэж иргэдийн үзэх түвшин                         | 10  |
| 7 | Урт хугацааны итгэлцэл ба бодлогын тогтвортой байдал | Татварын бодлогын өөрчлөлт байнга гардаг гэсэн айдас буурсан эсэх   | 10  |

## **2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал**

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон тухайн зохицуулалтын уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй байдлыг үнэлнэ. Хуулийн төслөөс “Харилцан уялдаа” гэх шалгуурт нийцээгүй зүйл, заалтууд болон бусад хуулийн зохицуулалттай зөрчилдсөн, давхардсан, хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан зэрэгт анхаарлаа.

Энэ шалгуур нь Үндсэн хууль болон бусад хуультай нийцэл, олон улсын нийцэл, заалтууд хоорондын уялдаа (дотоод логик), институциудын үүргийн уялдаа зэрэг нь хэрэгжилтэд шаардагдах нэмэлт зохицуулалтын хэрэгцээ байгаа эсэхийг үнэлнэ.

## **ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

### **3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал**

“Зорилгод хүрэх байдал”-ыг үнэлэхдээ хуулийн үзэл баримтлалд тусгагдсан хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх, хуулийг батлан хэрэгжүүлснээр тавьсан зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдож чадсан эсэхийг тухайн хуулийн төслийн үзэл баримтлал, түүний агуулгыг хуулийн төслийн үр нөлөөг үнэлж буй зохицуулалттай харьцуулан үнэллээ.

Хуулийн төслийн үзэл баримтлалын үндэслэл нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа- 2050" урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-

2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай" дунд хугацааны зорилтот хөтөлбөр зэргийн дагуу "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.2.1-д "Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх" бодлогод бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын суурь тогтолцооны тогтвортой байдлыг хангах, татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулах, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгох, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэргийг зорилт болгосон. Энэхүү хуулийн төслийн зорилт нь НӨАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал болж хуулийн төсөлд туссан эсэхийг үнэлнэ.

“Зорилгод хүрэх байдал” шалгуурын үр нөлөө

| ЗГ-ын хөтөлбөрийн зорилт                          | Хуулийн төслийн зохицуулалт   | Хүлээгдэж буй үр нөлөө  | Эрсдэл ба анхаарах зүйл |
|---|---|---|-------------------------|
| 1. Бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах | Татвар төлөх хугацааг хойшлуулах, НӨАТ суутган төлөгчийн босгыг нэмэгдүүлэх | ЖДБ-ийн хөрвөх чадвар сайжирч, бизнесийн үйл ажиллагаа өргөжих боломж бүрдэнэ | Төсвийн орлого буурах   |

### 3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Практикт хэрэгжих боломж” гэх шалгуур үзүүлэлтийн хүрээнд туршилтын ажиллагааг явуулахдаа тухайн хууль тогтоомжийн төслийн зохицуулалттай холбоотой тодорхой заалтуудыг сонгон даган мөрдөх болон практикт хэрэгжих боломжийг үнэлэхийг зорьсон болно.

#### Татвар төлөх хугацааны хөнгөлөлт

Татварын ерөнхий хуулийн 6.1.51-д заасан хууль даган мөрдөлтийн түвшин сайн буюу түүнээс дээш үнэлгээтэй татвар суутган төлөгч хүсэлт гаргасан тохиолдолд татвар төлөх хугацааг хоёр хүртэл сарын хугацаанд хойшлуулан татвар төлөх хугацааны хөнгөлөлт үзүүлнэ.

“Татвар төлөх хугацааны хөнгөлөлт” нь хууль даган мөрдөлтийн урамшууллын механизмыг бий болгож, татварын төлөлтийг сайжруулах, татвар төлөгчдөд ирэх мөнгөн урсгалын дарамт бууруулах, төр–бизнесийн итгэлцлийг нэмэгдүүлэх зорилготой тул практикт хэрэгжих боломжтой зохицуулалт юм.

| Үзүүлэлт  | Эерэг тал  | Сөрөг тал   |
|---|--|---|
| 1. Эдийн засгийн үр нөлөө (Эерэг, ялангуяа эргэлтийн хөрөнгийн дарамттай бизнесүүдэд тустай, гэхдээ татварын орлого удаахрах, буурах эрсдэлтэй) | Мөнгөн урсгалын уян хатан байдал олгох тул татвар төлөлтийн сахилга батыг нэмэгдүүлнэ. Импортын татварыг хойшлуулах боломж нь гадаад худалдааны зардлыг жигдлэх, уян хатан болгох. | Татвар хойшлуулсан ААН-үүдийн зарим нь хугацаандаа төлж чадахгүй байх эрсдэлтэй. Хууль даган мөрдөлтийн түвшнийг үнэлэх аргачлалд НББ-ийн мөнгөн ба аккрузель шийдэл тодорхой |

|   |   |  |
|---|---|--|
|   |   | бус, ойлголт бүрэн нэвтрээгүй.   |
| 2. Нийгмийн үр нөлөө (Эерэг, татварын шударга ёс, итгэлцэлд сайн нөлөөтэй)                      | Татварын итгэлцэлд эерэг “Үүргээ хэрэгжүүлдэг татвар төлөгч”-ийг урамшуулах нь шударга ёсны зарчмыг мэдрүүлж, татварын ёс зүйн соёлыг дэмжинэ.  | Жижиг бизнесүүд энэ хөнгөлөлтөөс гадуур үлдэх эрсдэлтэй. Хуулийн дагуу бүрэн тайлагнадаггүй, даган мөрдөлт үгүй бизнесүүд ялгаатай нөхцөл байдалд орох                               |
| 3. Институцийн үр нөлөө (Ил тод, автоматжсан даган мөрдөлтийн үнэлгээний систем хязгаарлагдмал) | Татварын орлого урт хугацаанд тогтвортой болно. Татвар төлөгчдөд хугацааны хөнгөлөлт үзүүлэх нь татвар төлөлтийн соёл, сайн дурын төлөлт нэмэгдэнэ. Татварын өр урт хугацаандаа буурна. | Цахим автомат систем, татвар хойшлуулах шийдвэрийг нягтлан бодох бүртгэл, мэдээллийн системийн хяналт сул, хойшлуулсан төлбөрийн биелэлт, эргэн төлөлтийн ил тод байдлын механизмгүй |

Татварын албаны хууль даган мөрдөлтийн үнэлгээний аргачлалыг олон нийтэд ил тод болгож, цахим автомат системтэй уялдуулах, татвар хойшлуулах шийдвэрийг нягтлан бодох бүртгэл, мэдээллийн системээр хянах дижитал модуль боловсруулах, хойшлуулсан төлбөрийн биелэлт, эргэн төлөлтийг хянах тусгай дүн шинжилгээ бүхий системийг хэрэгжсэнээр хэрэгжих боломж илүү болно.

### 3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Татвар төлөх хугацааны хөнгөлөлт” нь татварын төлбөрийн төлөлтийг цаг хугацааны хувьд хойшлуулж буй агуулга оршино. Хөнгөлөлт бол татварт төлбөл зохих татвараа бууруулах гэсэн агуулгатай иймээс энэ үг хугацаанд хэрэглэх нийцтэй биш юм.

Нэр томъёоны уялдаа: НӨАТ-ын тухай хуулийн төслийн “Татвар суутган төлөгч” нэр томъёо нь “татвар ногдуулах этгээд<sup>10</sup> (taxable person)<sup>11</sup>” гэсэн агуулгыг илэрхийлнэ. “Withholding agent” (суутган төлөгч) гэдэг нэр томъёо өөр утгатай, орлогын албан татварт хэрэглэдэг. Олон улсын практикт хуулийн нэр томъёог ойлгомжтой, нэг утгатай байлгахыг зөвлөдөг. НӨАТ-д “taxable person/taxable supplier” гэж ашиглаж, тусад нь “withholding agent” эсвэл “tax withholding agent” гэдгийг хариуцлага өөр, тусгай механизмд тусгаарлан ашигладаг байна. ЭЗХАХБ-ын зөвлөмжүүд болон олон улсын НӨАТ судалгаа<sup>12</sup>-нд энэ зарчмыг дэмждэг ажээ.

Татвар ногдуулан төлөгч гэдэг нь ерөнхийдөө бизнес эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч эсвэл мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгч байдаг. Ийм статус бүхий этгээд нь:

- НӨАТ-ыг ногдуулах,
- НӨАТ-ыг хураах буюу цуглуулан авах,

<sup>10</sup> Taxable person (татвар ногдуулах этгээд) — any person who independently carries out an economic activity and is required under this Law to charge, account for and remit VAT.” (Татвар ногдуулах этгээд) - энэ хуульд заасны дагуу НӨАТ ногдуулах, тооцох, шилжүүлэх (тайлагнах) үүрэгтэй аж ахуйн үйл ажиллагааг бие даан эрхэлдэг аливаа этгээдийг хэлнэ.)

<sup>11</sup> [https://taxation-customs.ec.europa.eu/taxation/vat/vat-directive/taxable-persons-under-eu-vat-rules\\_en?utm\\_source=chatgpt.com](https://taxation-customs.ec.europa.eu/taxation/vat/vat-directive/taxable-persons-under-eu-vat-rules_en?utm_source=chatgpt.com)

<sup>12</sup> [https://www.oecd.org/content/dam/oecd/en/publications/reports/1998/07/value-added-taxes-in-central-and-eastern-european-countries\\_g1ghg902/9789264163492-en.pdf?utm\\_source=chatgpt.com](https://www.oecd.org/content/dam/oecd/en/publications/reports/1998/07/value-added-taxes-in-central-and-eastern-european-countries_g1ghg902/9789264163492-en.pdf?utm_source=chatgpt.com)

- Татварын албанд төлөх үйлдлээ татварын тайлангаар нотолж баримтжуулах<sup>13</sup> үүрэгтэй этгээд юм.

Асуудал нь: Монгол орчуулгад “татвар суутган төлөгч” гэдэг нь хэл зүйн болон агуулгын хувьд хоёрдмол утга үүсгэнэ. Учир нь “татвар төлөгч” гэдэг суурь ойлголт Монгол Улсын Татварын ерөнхий хуульд «татвар төлөгч»(6.1.20), «суутган төлөгч»(6.1.19) нэр томъёоны тодорхойлолттой “татвар суутгагч” гэсэн ойлголтын агуулга нийцэхгүй зөрчилтэй болно.

### 3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

| № | Үзүүлэлт   | Тайлбар   |
|---|--|---|
| 1 | Ил тод байдал ба нээлттэй байдал                     | Хуулийн төсөл боловсруулахад оролцогч талуудын оролцоо, санал тусгах механизмыг бүрэн хангасан байна. Олон нийтийн хэлэлцүүлгийг олон төрлийн хэлбэрээр буюу цахим болон биетээр оролцох боломжийг хангасан байна. Сангийн яамны вэбсайт болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байршуулж санал авсан байна. |
| 2 | Шударга, тэгш байдлын хүлээлт                        | НӨАТ-ын шинэчилсэн тогтолцоо татвар төлөгчдийн хооронд шударга хандлагатай гэж хүлээн зөвшөөрөгдөх түвшин өндөр байх магадлалтай байна.   |
| 3 | Хэрэгжилтийн хялбар байдал (compliance cost)         | ААН, иргэдийн хувьд тайлагнал, бүртгэл, хяналт хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх магадлал бага байна.   |
| 4 | Бизнесийн өрсөлдөх чадварт үзүүлэх нөлөөний ойлголт  | Хуулийн төсөл бизнесийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ гэсэн хүлээлт өндөр байна. Бизнес идэвхжих, тэлэх бололцоогоор хангагдаж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж нэмэгдэх хүлээлттэй.   |
| 5 | Урт хугацааны итгэлцэл ба бодлогын тогтвортой байдал | Татварын бодлогын өөрчлөлт байнга гардаг гэсэн айдас буурахаар байна.   |

### 3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хуулийн төслөөс “Харилцан уялдаа” гэх шалгуурт нийцээгүй зүйл, заалтууд болон бусад хуулийн зохицуулалттай зөрчилдсөн, давхардсан, хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан зүйл байхгүй байна.

## ДӨРӨВ. ҮР ДҮНГ ДҮГНЭЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт бүрээр дараах байдлаар дүгнэлээ.

### 4.1. ДҮГНЭЛТ

#### 1.Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

<sup>13</sup> [https://taxation-customs.ec.europa.eu/taxation/vat/vat-directive/taxable-persons-under-eu-vat-rules\\_en?utm](https://taxation-customs.ec.europa.eu/taxation/vat/vat-directive/taxable-persons-under-eu-vat-rules_en?utm)

Хуулийн төсөл зорилгодоо нийцэж байна, нийтээр даган мөрдөж хэрэгжүүлбэл хууль даган мөрдөлт сайжрах, бизнесийн үйл ажиллагаа өргөжих, бизнес идэвхжих, тэлэх боломжтой.

## **2.Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хувьд холбоотой зохицуулалтыг шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийн хэрэгжих байдлыг сонгон авч үнэлсэн ба дараах дүгнэлтэд хүрч байна.

Хуулийн төсөл нь бодлогоо хангах чиглэлтэй, цахимжсан хяналт, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилготой боловч практикт хэрэгжих чадавхын хувьд дунд түвшний үнэлгээтэй байна. Учир нь орон нутгийн и-баримт бүртгэл, интернет холболт сул, И-Монголиа, ТЕГ, банкуудын мэдээлэл солилцох API холболт, шатлалтай хэрэгжүүлэх (6.1) заалтын хэрэгжилт зэргийг илүү тодорхой зохицуулалт, хүний болон институцийн чадавх бэлтгэгдэж байж хэрэгжилт дэмжигдэхээр байна. Нийслэл, 21 аймаг, бүх сумдын түвшинд шинэ журам, цахим хяналт нэвтрүүлэх бэлтгэл хангагдах, эдийн засгийн болон зан үйлийн хүчин зүйлсийн сөрөг нөлөөлөл хуулийн хэрэгжилтэд анхаарах асуудал юм.

## **3.Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

Хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томьёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ерөнхийдөө ойлгомжтой байгаа хэдий ч зарим нэр томьёог анхаарах нь зүйтэй байна. Иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байна.

## **4.Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

Хуулийн төсөлд шинээр бий болгож буй зохицуулалтыг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэхээр байна.

## **5.Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн зохицуулалттай зөрчилдсөн, давхардсан, хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан зэрэг нөхцөл байдлыг үнэлэн дараах дүгнэлтэд хүрлээ.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бодлогын баримт бичгүүд болон олон улсын стандарттай ерөнхийдөө сайн уялдсан, эрх зүйн шинэчлэл, цахимжуулалтын зорилгод нийцсэн байна.

Хуулийн төсөл нь зорилгоо биелүүлэх бүрэн боломжтой ч эрх зүйн нэр томьёо, цахим дэд бүтэц, иргэдийн зан үйлийн хандлагын саад зэргийг даван туулж бодит нөхцөлийг бүрдүүлэхэд “эрх зүйн тогтолцоо–институци–эдийн засаг–зан үйл” гэсэн 4 багц хүчин зүйлд суурилсан сайжруулалт шаардлагатай юм.

## **4.2. ЗӨВЛӨМЖ**

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлсний үр дүнгийн дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

### **1.Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

- Татварын шударга байдлын үзүүлэлтийг хууль хэрэгжих хяналтын үзүүлэлт болгох.
- ААНБ-д НӨАТ-ын өгөгдлийн боловсруулалтыг нягтлан бодох бүртгэлийн мэдээлэлд суурилах, цахим төлбөрийн системд СТОУС-д суурилсан татварын нөлөөллийг тооцох, нэгтгэх (IFRS-based reporting integration) зохицуулалтыг тусгах.

### **2.Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

Хуулийн төслийн практик хэрэгжилтийн үзүүлэлтэд сонгон авсан заалтуудын үнэлгээнд институци хоорондын уялдаа, иргэдийн даган мөрдөх, мэдээлэл технологийн орчны чадамжийн сул болон сөрөг талыг сайжруулах зохицуулалтыг хэрэгжүүлэх. Үүнд:

- Цахим төлбөрийн баримт, цахим нэхэмжлэлийн системийн хамралт худалдаа үйлчилгээний нэгж, ялангуяа орон нутагт иргэдийн оролцоог сайжруулах зохицуулалт хийх
- Татварын хяналт, цахим өгөгдлийн шинжилгээ, эрсдэлд суурилсан хяналтад зайлшгүй хэрэгжүүлэх зохицуулалтыг холбох

### **3.Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

Цахим төлбөрийн баримтын системийн хамралт: Худалдаа үйлчилгээний нэгж, хөдөө орон нутгийн холболтын дэд бүтцийг сайжруулах, хэрэглээ болгох зан үйлд нөлөөлөх механизмыг сайжруулах

### **4.Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

- СТОУС-ын “Орлого хүлээн зөвшөөрөлт” болон ЭЗХАХБ НӨАТ/БҮТ заавартай суурь уялдааг хангах.
- Хэрэглэгчийн мэдээллийн хамгаалалт, нууцлалын зохицуулалтыг “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль” – баримт шаардах, мэдээлэл авахтай уялдуулах.
- АРІ нэгдсэн стандарт, и-баримт системийг хувийн хэвшлийн POS, ERP системтэй илүү нээлттэй болгохыг зохицуулах.
- НӨАТ, Гаалийн татвар, ААНОАТ, ХХОАТ-ын мэдээллийн системүүдийн уялдааг бүрэн шийдвэрлэх механизмыг зохицуулах.
- Нийгмийн хүлээн зөвшөөрөлтийг нэмэгдүүлэх, иргэдийн дижитал хэрэглээ, урамшууллын механизмыг (и-баримтын урамшуулал, буцаан олголт) хадгалах.
- Хуурамч баримтын илрүүлэлтэд өгөгдлийн шинжилгээний автомат системийг хэрэгжүүлэх, хяналтын механизмыг бусад хуулиудтай холбож уялдуулах

- ТОВЧИЛСОН ҮГС

ААН- Аж ахуй нэгж

ААНОАТ- Аж ахуй нэгжийн орлогын албан татвар

ЕХ- Европын холбоо

ЖДҮ- Жижиг дунд үйлдвэрлэл

ЖДБ- Жижиг дунд бизнес

НӨАТ- Нэмэгдсэн өртгийн албан татвар

ХХОАТ- Хувь хүний орлогын албан татвар

ТЕХ- Татварын ерөнхий хууль

ТЕГ-Татварын ерөнхий газар

ОУВС- Олон улсын Валютын сан

ТМЗН- Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг

СТОУС- Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт

ЭЗХАХБ- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж, эрх зүйн акт

*Монгол хэлээр:*

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992)
2. Хууль тогтоомжийн тухай хууль, (2015)
3. Татварын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/, (2019)
4. Нэмэгдсэн өртгийн татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, (2015)
5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ (2019)
6. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай, (2019)
7. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл (СЯ. 2026)
8. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, хөгжлийн бодлого, хөтөлбөр, стандарт

*Монгол хэлээр:*

1. Алсын хараа- 2050
2. Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
3. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
4. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал
5. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга
6. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо
7. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. 2026 он
8. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааны тайлан
9. СТОУС 15. Харилцагчтай байгуулсан гэрээний орлого
10. Г.Алтанзаяа. Татвар, 2020
11. Г.Алтанзаяа. Татварын бүртгэл II. 2025

12. “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж байна, <https://www.parliament.mn/nn/74036>

Гадаад хэлээр:

1. OECD — *International VAT/GST Guidelines* (2017).
2. OECD — *The Role of Digital Platforms in the Collection of VAT/GST on Online Sales* (2019).
3. European Commission — *VAT One-Stop Shop / Import One-Stop Shop (IOSS)* (e-commerce package, 2021).
4. OECD Tax Administration Diagnostic Assessment Tool (TADAT) ба IMF VAT Gap Analysis Framework (V-GAF)
5. Getting the Public on Side. How to Make Reforms Acceptable by Design  
[https://www.oecd.org/content/dam/oecd/en/publications/reports/2025/03/getting-the-public-on-side\\_3a30e3c5/262255fd-en.pdf](https://www.oecd.org/content/dam/oecd/en/publications/reports/2025/03/getting-the-public-on-side_3a30e3c5/262255fd-en.pdf)
6. EU Directive-д “electronically supplied services” EU Council Directive 2006/112/EC, Article 7
7. OECD (2021). *Statement on a Two-Pillar Solution to Address the Tax Challenges Arising from the Digitalisation of the Economy*.
8. Checklist on Law Drafting and Regulatory Management in Central and Eastern Europe. OECD
9. VALUE-ADDED TAXES IN CENTRAL AND EASTERN EUROPEAN COUNTRIES A Comparative Survey and Evaluation.
10. OECD (2021). *Statement on a Two-Pillar Solution to Address the Tax Challenges Arising from the Digitalisation of the Economy*.
11. OECD SIGMA Paper No.55 – Principles of Good Law Drafting (2019)
12. [https://taxation-customs.ec.europa.eu/taxation/vat/vat-directive/taxable-persons-under-eu-vat-rules\\_en?utm](https://taxation-customs.ec.europa.eu/taxation/vat/vat-directive/taxable-persons-under-eu-vat-rules_en?utm)
13. [https://www.oecd.org/content/dam/oecd/en/publications/reports/1998/07/value-added-taxes-in-central-and-eastern-european-countries\\_g1ghg902/9789264163492-en.pdf?utm](https://www.oecd.org/content/dam/oecd/en/publications/reports/1998/07/value-added-taxes-in-central-and-eastern-european-countries_g1ghg902/9789264163492-en.pdf?utm)
14. [https://taxation-customs.ec.europa.eu/taxation/vat/vat-directive/taxable-persons-under-eu-vat-rules\\_en?](https://taxation-customs.ec.europa.eu/taxation/vat/vat-directive/taxable-persons-under-eu-vat-rules_en?)
15. [https://taxation-customs.ec.europa.eu/taxation/vat/vat-directive/taxable-persons-under-eu-vat-rules\\_en?utm\\_source](https://taxation-customs.ec.europa.eu/taxation/vat/vat-directive/taxable-persons-under-eu-vat-rules_en?utm_source)

Монгол хэлээр:

- <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368388631&showType=1>  
[https://legalinfo.mn/storage/uploads/process/202509/file\\_1756730044251012\\_17143739132592371.pdf](https://legalinfo.mn/storage/uploads/process/202509/file_1756730044251012_17143739132592371.pdf)  
<https://legalinfo.mn/mn/detail/14403>  
<https://legalinfo.mn/mn/detail/14525>  
[https://legalinfo.mn/mn/discussiondetail/17432686266352?type=LIS\\_LAW&page=1](https://legalinfo.mn/mn/discussiondetail/17432686266352?type=LIS_LAW&page=1)  
[https://legalinfo.mn/storage/uploads/process/202509/file\\_1756730044251012\\_17143739132592371.pdf](https://legalinfo.mn/storage/uploads/process/202509/file_1756730044251012_17143739132592371.pdf)  
[https://legalinfo.mn/storage/uploads/process/202509/file\\_1756730044903425\\_17143739132592370.pdf](https://legalinfo.mn/storage/uploads/process/202509/file_1756730044903425_17143739132592370.pdf)  
[https://mof.gov.mn/files/uploads/article/-%D0%B8%D0%B9%D0%BD\\_%D0%A2%D0%B0%D0%BD%D0%B8%D0%BB%D1%86%D1%83%D1%83%D0%BB%D0%B3%D0%B0\\_%28%D1%82%D0%BE%D0%B2%D1%87%2C\\_%D0%B4%D1%8D%D0%B%D0%B3%D1%8D%D1%80%D1%8D%D0%BD%D0%B3%D2%AF%D0%B9%2C\\_%D0%B0%D0%BD%D0%B3%D0%BB%D0%B8%29.pdf](https://mof.gov.mn/files/uploads/article/-%D0%B8%D0%B9%D0%BD_%D0%A2%D0%B0%D0%BD%D0%B8%D0%BB%D1%86%D1%83%D1%83%D0%BB%D0%B3%D0%B0_%28%D1%82%D0%BE%D0%B2%D1%87%2C_%D0%B4%D1%8D%D0%B%D0%B3%D1%8D%D1%80%D1%8D%D0%BD%D0%B3%D2%AF%D0%B9%2C_%D0%B0%D0%BD%D0%B3%D0%BB%D0%B8%29.pdf)  
<https://www.supremecourt.mn/mn/print?id=42238>